



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Нийцлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 29 дүгээр зүйлийн 29.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/12 дугаар тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нийслэлийн 2023 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах"-д хийсэн нийцлийн аудитын /НТАГ-2022/14-11-ШТА-ТД/ тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Аудитын удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

3. Тайланг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Үндэсний Аудитын газарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



# АУДИТЫН ТАЙЛАН

---

“Нийслэлийн 2023 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах” аудит

АУДИТЫН КОД: НТАГ-2022/14-11-ШТА-ТД

---

Аудитын удирдлага, зохицуулалтын хэлтэс

Хэлтсийн дарга, аудитын менежер

Ц.Бат-Өлзий

Ахлах аудитор Д.Ичин

Аудитор С.Лхагвасүрэн, У.Оюунхүү

Гэрээт ажилтан М.Номин-Эрдэнэ

Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө

Г корпус 524 дүгээр өрөө.

Улаанбаатар хот  
2022 он

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас [www.audit.mn](http://www.audit.mn)

---

## АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын талаарх ерөнхий мэдээлэл .....	4
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	5
Аудитын зорилт.....	5
Аудитын хамарсан хүрээ .....	5
Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл .....	5
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд.....	5
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн .....	6
БҮЛЭГ 1.Төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх	6-9
БҮЛЭГ 2.Төсвийн төсөлд зарлага бууруулах боломжийг бүрэн тусгасан эсэх	10-11
БҮЛЭГ 3. Төсвийн төсөлд төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх.....	12-13
Аудитын дүгнэлт .....	14
Аудитын зөвлөмж .....	15
Хавсралтууд.....	16-25
Холбогдох байгууллагын санал.....	26

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
УСУГ	Ус сувгийн удирдах газар
ОСНААУГ	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
НАЗХГ	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ХИХУГ	Хэсэгчилсэн инженерийн хангамж удирдах газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
НД	Налайх дүүрэг
МУЗЗНДНТУ	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл

## **АУДИТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

### **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2022 оны төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

### **Аудитын зорилт**

Нийслэлийн 2023 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт, зөвлөмж боловсруулан нийслэлийн ИТХ-д хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх;
- Зарлагыг бууруулах боломжийг бүрэн тусгасан эсэх;
- Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх.

### **Аудитын хамарсан хүрээ**

Нийслэлийн 2023 оны төсвийн төсөл, түүний танилцуулга, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төслийг хамруулан аудит хийв. Аудитын талбарын ажлын хүрээнд Нийслэлийн ЗДТГ, Татварын газар, Өмчийн ашиглалт, удирдлагын газар, Хөрөнгө оруулалтын газар, Автозамын хөгжлийн газар, Ус сувгийн удирдах газар зэрэг байгууллагуудаас судалгаа авч дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

### **Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл**

АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” болон батлагдсан заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

### **Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд**

Аудитад Төсвийн тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөл болон холбогдох заавар, журмуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

## **Талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Нийслэлийн Засаг дарга Нийслэлийн 2023 оны төсвийн төслийг холбогдох шаардлагад нийцүүлэн нэгтгэн боловсруулж нийслэлийн ИТХ-д өргөн мэдүүлэх үүрэгтэй. Нийслэлийн ИТХ-д өргөн мэдүүлсэн Нийслэлийн 2023 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Нийслэл дэх Төрийн аудитын газрын үүрэг юм.

## **Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн**

Аудитыг аудитын удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, аудитын менежер Ц.Бат-Өлзий хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг ахлах аудитор Д.Ичин хэрэгжүүлж, аудитор У.Оюунхүү, С.Лхагвасүрэн, гэрээт ажилтан М.Номин-Эрдэнэ нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

## **БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨСӨЛД ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ**

### **Ерөнхий мэдээлэл:**

Нийслэлийн 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа татварын бүртгэлийг сайжруулах, цахим төлбөрийн баримтын системийг үе шаттай хөгжүүлэх, бүртгэлийг сайжруулах замаар орлогыг нэмэгдүүлэх, төрийн албаны цалин хөлсний тогтолцоог бүтээмжтэй нь уялдуулж шинэчлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах, санхүүгийн сахилга батыг мөрдүүлж ажиллах чиглэл, зарчмыг баримталжээ.

Нийслэлийн 2023 оны төсвийн төсөлд нийслэлийн нийт орлогыг 1,742,339.0 сая төгрөг ба нийслэл, дүүргийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 1,634,460.9 сая төгрөгөөр төсөвлөжээ.

Улаанбаатар хотын төсөвт татварын орлогоор 334,830.7 сая, татварын бус орлогоор 175,047.1 сая, дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын шилжүүлгээр 871,256.9 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгээс 16,249.9 сая, өмнөх оны үлдэгдлээс 237,076.3 сая, төсвийн байгууллагуудын өөрийн орлогоор 18,064.6 сая төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийслэлийн 2023 оны төсвийн төсөлд орлогын боломжит эх үүсвэрийг дайчлан төлөвлөж 2022 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 2.2 орчим хувиар нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Нийслэлийн 2023 оны төсвийн төсөлд зарим орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж байна. Үүнд:

### **1.ҮХЭХАТ-ын орлого:**

ҮХЭХАТ-ын тухай хуулийн хэрэгжилтэд 2020-2021 онд хийсэн нийцлийн аудитаар УБЕГ-ын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд татвар ногдох 27,200 орчим үл хөдлөх эд хөрөнгө бүртгэлтэй байгаагаас нийслэлийн 9 дүүргийн Татварын хэлтсийн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 17,700 гаруй үл хөдлөх эд хөрөнгө бүртгэгдэж татвар ногдуулж, 9,515 үл хөдлөх эд хөрөнгө татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдээгүй, татвар ногдуулаагүй байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 203 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ”-нд үндэслэн татварын зорилгоор жишиг байдлаар дээрх үл хөдлөх хөрөнгүүдийн үнэлгээг татварын байгууллагаар тооцоолуулахад 2018 онд 15,927.2 сая, 2019 онд 16,517.8 сая, нийт 32,445.0 сая төгрөгийн татвар ногдохоор тооцоо гарсан.

УИХ-аас 2021 оны 7 дугаар сарын 7-нд ҮХЭХАТ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1<sup>1</sup>, 7 дугаар зүйлийн 7.1.2<sup>2</sup>, 7.1.6<sup>3</sup> дах заалтуудад нэмэлт өөрчлөлтийг оруулжээ.

<sup>1</sup> “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-2.0 хувиар тооцож ногдуулна.”

<sup>2</sup> “иргэн, хуулийн этгээдийн өмчилж байгаа аймаг, суман дахь орон сууц, нийслэл дэх хоёр орон сууц;”

<sup>3</sup> “нийслэл хотын тусгай бүсэд бүртгэгдсэн барилга байгууламж.”

НИТХ-ын 2012 оны 5/18 дугаар тогтоолоор баталсан татварын хэмжээг ҮХЭХАТ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын дагуу шинэчлэн батлаагүй байна.

Дээрх байдлаас дүгнэн тооцоолоход ҮХЭХАТ-ын орлогыг **32,797.7 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. Үүнд:

1. Нийцлийн аудитаар илэрсэн үл хөдлөх эд хөрөнгө татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдээгүй, татвар ногдуулаагүй, татварын хувь хэмжээг зөрүүтэй тооцсон, татвар ногдуулаагүй зөрчлүүдийг арилгуулахаар өгсөн албан шаардлагын үлдэгдэл 13,169.2 сая төгрөгөөс татварын ногдуулалтыг 50 хувиар тооцоход 6,584.6 сая төгрөг; /Хавсралт №01/
2. Татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоосноор хуучин 1.0 хувийн татварын хэмжээг 50 хувиар нэмэгдүүлэхэд 26,213.1 сая төгрөг; /Хавсралт №02/
3. ҮХЭХАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2<sup>4</sup> дах заалтын дагуу нийслэл дэх 2-оос дээш тооны орон сууцтай Монгол улсын болон гадаадын иргэний судалгаа, бүртгэлийг УБЕГ-аас авч хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлж татвар ногдуулахад орлого нэмэгдэх боломжтой.

## **2.ОНӨААН-ээс төвлөрүүлэх ноогдол ашиг:**

2022 онд нийт 322.8 сая төгрөгийн ноогдол ашгийн орлого батлагдаж, 2022 оны ХБГ-ээр 415.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 92.2 сая төгрөг буюу 28.6 хувиар давж биелэхээр байна.

Нийслэлийн 9 дүүргийн 10 ОНӨААН нь 2020 оны санхүүгийн тайлангаар нийт 1,298.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байхад дүүргийн ИТХ-аас ноогдол ашгийн орлогыг 2022 онд батлаагүй нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9<sup>5</sup>, 23.9.1<sup>6</sup> дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

УИХ-ын “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2021 оны 88 тогтоолын 1.1. “Төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээдүүд жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 50 хувь болон төрийн эзэмшилд хамаарах эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр ноогдол ашиг тооцон хуваарилж төсөвт төвлөрүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авахыг чиглэл болгон ажиллах;” гэж заасан байна.

Нийслэл, дүүргийн өмчит 66 ОНӨААН-ээс 14 ААН нь нийт 5,150.0 сая төгрөгийн цэвэр ашигтай, орон нутгийн эзэмшилд хамаарах 17,255.2 сая төгрөгийн эздийн өмчтэй байна. (нийслэлийн өмчит 3 ААН- 3,920.0 сая төгрөг цэвэр ашигтай, 13,258.9 сая төгрөгийн эздийн өмчтэй, 9 дүүргийн 11 ААН 1,229.2 сая төгрөгийн цэвэр ашигтай, 3,996.3 сая төгрөгийн эздийн өмчтэй.)

УИХ-ын дээрх тогтоолын дагуу ноогдол ашгийн тооцооллыг хийхэд нийт 2,655.0 сая төгрөгийн ноогдол ашгийн орлогыг нийслэл, дүүргийн төсөвт төвлөрүүлэхээр байна. Үүнээс нийслэл, дүүргийн төсвийн төсөлд тусгасан 500.0 сая төгрөгийг хасаж тооцоход **2,155.0 сая** төгрөгийг орлого орох боломж байна. /Хавсралт №03/

<sup>4</sup> “иргэн, хуулийн этгээдийн өмчилж байгаа аймаг, суман дахь орон сууц, нийслэл дэх хоёр орон сууц;” /Энэ заалтыг 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

<sup>5</sup> “Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:”

<sup>6</sup> “орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ноогдол ашиг;”

### **3. Малын тоо толгойн албан татвар:**

Нийслэлийн хэмжээнд 2020 онд 468,690 толгой, 2021 онд 443,320 толгой мал жилийн эцсийн мал тооллогоор тоологдсон байна.

2022 онд малын тоо толгойн албан татвараар 267.0 сая төгрөг батлагдаж, 2022 оны ХБГ-ээр 227.1 сая төгрөгийн орлого төвлөрч 69.9 сая төгрөг буюу 23.5 хувиар тасрахаар байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1<sup>7</sup>, 6.2<sup>8</sup> дах заалтуудын дагуу дүүргийн ИТХ-аас малын төрөл тус бүрээр татварын хэмжээг тогтоосон байдлыг үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. СХД, БНД, БХД, НД-ийн ИТХ-ууд 300-2,000.00 төгрөгөөр малын төрөл тус бүрээр тогтоож баталсан байна.
2. БЗД-ийн ИТХ нь 2020 оны 12 дугаар сарын 25-ны 11 дүгээр тогтоолоор малын тоо толгойд ногдуулах албан татварын хувь хэмжээг “0” төгрөгөөр баталсан нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.3<sup>9</sup> дах заалттай нийцээгүй байна. Дүүргийн ИТХ нь малын тоо толгой албан татварын хувь хэмжээг одоо болтол шинэчлэн тогтоогүй нь хуулийн 6.2 дах заалтыг хэрэгжүүлээгүй, дүүргийн төсвийн орлогыг бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.
3. ХУД-ийн ИТХ нь малын тоо толгойд ногдуулах албан татварын хувь хэмжээг тогтоогүй нь хуулийн 6.2 дах заалтыг хэрэгжүүлээгүй, дүүргийн төсвийн орлогыг бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Дүүргийн Татварын хэлтсээс 2021 оны 2/965 дугаар албан бичгээр малын тоо толгойд ногдуулах албан татварын хувь хэмжээг тогтоох тогтоолын төслийг өргөн барьсан боловч дүүргийн ИТХ одоо болтол албан татварын хэмжээг батлаагүй байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1<sup>10</sup>, 5.2<sup>11</sup> дах заалтуудын дагуу 2021, 2022 оны малын тоо толгойн албан татварын ногдуулалтыг тооцож үзэхэд 222.9 сая төгрөгөөр дутуу ногдуулжээ. Үүнд:

1. Албан татварын хувь хэмжээг тогтоосон 4 дүүрэг 2021 онд 320.5 сая төгрөгийн албан татвар ногдуулахаас нийт 116.3 сая төгрөгийн татварыг ногдуулж, 204.2 сая төгрөгийг дутуу; (СХД-123.2 сая, БНД-62.5 сая, НД-4.4 сая, БХД-14.1 сая)
2. СХД, БХД, НД-үүд 2022 онд малын тоо толгойн албан татварыг нийт 18.7 сая төгрөгөөр дутуу; (СХД-3.8 сая, НД-6.3 сая, БХД- 8.6 сая)

Иймд Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байгаа зөрчлийг арилгуулж БЗД, ХУД-ийн мал тоо толгойн албан татварын ногдуулалтыг бусад дүүргийн тогтоосон дундаж хувь хэмжээгээр тооцоход **115.6 сая** төгрөгөөр нийслэлийн төсвийг орлогыг нэмэгдүүлэх боломж байна. /Хавсралт №04/

### **4. Түрээсийн орлого:**

Нийслэлийн өмчийн байруудын талаарх судалгаа мэдээллийг бүрэн бүрдүүлж шат шатны хяналтыг сайжруулан, харилцан уялдааг хангаж

<sup>7</sup> "Нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байна."

<sup>8</sup> "Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно."

<sup>9</sup> "Малчны амьжиргааг дэмжих зорилгоор малчны өмчилж байгаа малын тоо толгойноос хамааран ногдох албан татварын хэмжээг 0 төгрөг байхаар тогтоож болно."

<sup>10</sup> "Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна."

<sup>11</sup> "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно."

ажилласнаар түрээсийн орлогыг **1,146.3** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой. Үүнд:

1.НТАГ-аас 2021 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийслэлийн өмчийн байрыг 2018-2020 онд иргэн, ААНБ-д түрээсийн гэрээгүйгээр эзэмшүүлсэн хугацааны 1м<sup>2</sup> талбайн үнэлгээг НИТХТ-ийн 2018 оны 40 дүгээр тогтоолын дагуу тооцон тулган баталгаажуулахад нийслэлийн өмчид бүртгэлтэй нийт 12 барилга байгууламжийн 14,567.0м<sup>2</sup> талбайг гэрээгүйгээр 99 иргэн, ААНБ-д ашиглуулсан хугацааны нийт 992.9 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлээгүй байсан. Цаашид түрээсийн гэрээ байгуулж ажилласнаар дээрх хэмжээний орлогыг төсөвт төвлөрүүлэх боломжтой. /Хавсралт №05/

2.Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт дүүргийн нутгийн захиргааны нэгдсэн барилга ашиглалтад орсонтой холбогдуулан тус барилгад улсын төсвийн 2, орон нутгийн өмчит 1, цайны газар *(зориулалтаар ашиглуулахаар өрөө бэлтгэсэн боловч одоогоор тоног төхөөрөмж бүрэн бусаар шалтгаалан түрээслэгдээгүй)*, нийт 4 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч одоогоор түрээсийн гэрээ байгуулаагүй, төлбөр төлдөг байна.

ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны 49 дүгээр тогтоолоор баталсан үнэлгээгээр түрээсийн орлогыг тооцвол нийт орлого 153.4 сая төгрөг болж, түрээсийг орлого нэмэгдэх боломжтой байна. /Хавсралт №06/

## БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ТӨСӨЛД ЗАРЛАГА БУУРУУЛАХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ

Нийслэлийн 2023 оны төсвийг боловсруулахдаа Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн дагуу урсгал зарлагын өөрчлөлтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, төсвийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлийг баримталжээ.

Нийслэлийн 2023 онд төсвийн төсөлд 9 дүүргийн суурь зарлагыг 197.3 тэрбум төгрөгөөр тооцож төсөвлөсөн бөгөөд Улаанбаатар хотын урсгал зардлыг 669.7 тэрбум, улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэгт 593.4 тэрбум, 2 дүүрэгт олгох санхүүгийн дэмжлэгт 8.4 тэрбум, нийслэлийн төсвийн болон автозамын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтад 362.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

Нийслэлийн төсвөөс 2023 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 593.4 тэрбум төгрөг байхаар УИХ-аас баталсан нь 2022 оноос 425.5 тэрбум төгрөг буюу 3.5 дахин нэмэгдүүлсэн байна.

1.Нийслэлийн 2023 оны төсвийн урсгал зардлын төслийг боловсруулахдаа төрөөс хэрэгжүүлж буй бодлого, Төрийн хэмнэлтийн тухай хууль, төсвийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлийг баримтлан зарим зардлыг бууруулан төлөвлөсөн байна. Үүнд:

- Хангамж бараа материалын зардлыг 2021 оны гүйцэтгэлээс 7.7 хувь, 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 20.2 хувь
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 2021 оны гүйцэтгэлээс 14.9 хувь, 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 24.3 хувь
- Хөрөнгийн зардлыг 2021 оны гүйцэтгэлээс 14.5 хувь, 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 86.5 хувь бууруулж төлөвлөжээ.

2.Нийслэлийн 2023 оны төсвийн төсөлд тусгасан зардлаас тэвчиж болохуйц дараах зардлуудыг бууруулах боломжтой байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 388, 2022 оны 203, 204 дүгээр тогтоолын дагуу тэвчиж болох урсгал зардлыг *гадаад томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, сургалт, семинар зохион байгуулахтай холбоотой зардал...гм*) 50.0 хувь хүртэл буюу дунджаар **1,734.2** сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.
- Нийслэлийн Засаг даргын тамгын газрын төсөвт шүүхийн шийдвэрийн дагуу иргэд, ААН-д олгох төлбөрт **1,404.2** сая төгрөг төсөвлөсөн байгааг хасаж, Захиргааны Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу буруутай албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ авах шаардлагатай.

3.Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн “Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоолыг баталж “Засгийн газрын авто бааз” УТҮГ-ыг ТӨААТҮГ болгон өөрчилсөн. Үүний нэгэн адил НИТХ-аас дээрхтэй адил тогтоолыг гарган “Нийслэлийн Төр, захиргааны авто бааз” ОНӨТҮГ-ыг ОНӨААТҮГ болгон өөрчлөн зохион байгуулж төр захиргааны байгууллагуудад дуудлагаар автомашины үйлчилгээ үзүүлж, өөрийгөө санхүүжүүлэх тогтолцоонд шилжүүлбэл нийслэлийн төсвөөс 2023 онд

олгохоор санал болгосон санхүүжилт **1,409.0** сая төгрөгийг хэмнэх боломжтой болно.

4.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 зүйлийн 15.1.2 дах заалтын дагуу зарим чиг үүрэг, үйл ажиллагаа нь давхардсан орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг нэгтгэх, татан буулгах нь зүйтэй. ("Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК, "Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалтын менежмент" ХХК, зарим дүүргүүдийн ОНӨААТҮГ-ууд (БЗД-ийн 5 НҮГ-ууд, Хан-Уул дүүргийн 4 тохижилт үйлчилгээний ОНӨААТҮГ, "Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төв", "Дүүрэг хөгжлийн төв" ОНӨТҮГ-үүд, ЧД-ийн "Ногоон булан" амралт, сувилал, Ахмадын амралт ОНӨААТҮГ-ууд ... гм)

### **БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРЭН ТУСГАСАН ЭСЭХ**

**Ерөнхий мэдээлэл:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1, 67 дугаар зүйлийн 67.3-т төсвийн төслийг боловсруулах явцдаа олон нийтэд танилцуулж, иргэдийн санал хүсэлтийг тусгана гэж заасны дагуу Нийслэлийн 2023 оны төсвийн төслийг Ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулан иргэдийн саналыг авч, 9 дүүргийн 300 гаруй иргэдийг хамруулсан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж иргэдээс нийт 455 санал ирүүлснийг нийслэлийн санхүү, төсвийн боломжит эх үүсвэрийн хүрээнд судлан, төсвийн төсөлд тусгасан байна.

#### **3.1.НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:**

Нийслэлийн 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах, өмнөх жилүүдэд эхлүүлсэн төсөл арга хэмжээг хугацаанд нь дуусгах, ашиглалтад оруулах бодлогыг баримталж хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байна.

2023 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 523,707.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 73 төсөл арга хэмжээнээс 46,438.0 сая төгрөгийг, нийслэлийн замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх 273,536.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл арга хэмжээнээс 66,194.2 сая төгрөг буюу нийт 112,632.2 сая төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөсөн нь өмнөх оноос 6 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд шинээр гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн нийслэлийн хариуцах 8,000.0 сая, “Цахим Улаанбаатар” төсөлд 23,000.0 сая нийт 31,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх 46.438,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 73 төсөл арга хэмжээний 54.7% буюу 25,438.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 71 төсөл арга хэмжээ нь 2018-2022 онуудад он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ байна.

Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 28 төсөл арга хэмжээнээс 23,880.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл арга хэмжээ нь шинээр хэрэгжүүлэх, 249.656,3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 42,314.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 16 төсөл арга хэмжээ нь 2019-2022 онуудад он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ байна. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээ нь нийт 2023 онд хэрэгжих төсөл арга хэмжээний 64% хувийг эзэлжээ.

Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр 18,570.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16,249.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 80 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас нийслэлд хуваарилж буй шилжүүлгийн орлого 2022 онтой харьцуулахад 4.1 тэрбум төгрөгөөр өссөн буюу 32.5 тэрбум төгрөгөөр батлагджээ.

Нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх төсөл арга хэмжээнээс 24,172.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй

дараах 2 төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай 33.2.6<sup>12</sup>; шаардлагад нийцээгүй байна.

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн	Эх үүсвэр
1	"Цахим Улаанбаатар"	2023	2024	23,000.0	13,000.0	НХО
2	Бусад	2023	2023	1,172.9	1,172.9	ОНХС
				<b>24,172.9</b>	<b>14,172.9</b>	

Иймд дээр төсөл арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөх шаардлагатай байна.

### **3.2.ОНӨААН-ҮҮДИЙН ЗОРИЛТОТ ТҮВШИННИЙ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ, АШИГ, АЛДАГДЛЫН ТАЛААР:**

2.1. Нийслэлийн өмчит 23 аж ахуйн нэгжүүд 2021 онд нийт 281.1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, өмнөх оноос 4.1 тэрбум төгрөг буюу 1.4 хувиар буурсан. Үндсэн үйл ажиллагааны /борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалт болон ерөнхий удирдлагын зардал, үйл ажиллагааны бус зардал, татварын зардал/ болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд нийт 316.7 тэрбум төгрөгийг зарцуулж, 35.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Алдагдал өмнөх оноос 11.1 тэрбум төгрөг буюу 23.8 хувиар буурсан байна.

2.2. Нийслэлийн төсвөөс санхүүжилт авдаггүй, өөрийн үйл ажиллагаагаар орлого бүрдүүлж ажилладаг 23 аж ахуйн нэгжээс 13.0 хувь нь 3.9 тэрбум төгрөгийн ашигтай, 87.0 хувь нь 39.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Тухайлбал, УСУГ 13.8 тэрбум, ОСНААУГ 8.8 тэрбум, "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ 5.3 тэрбум, "Геодези, усны барилга, байгууламжийн газар" ОНӨААТҮГ 3.8 тэрбум, "Зорчигч тээвэр-3" ОНӨААТҮГ 2.0 тэрбум, "Нийслэлийн Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ 1.4 тэрбум, Нийслэлийн орон сууц корпорацн ХК 1.0 тэрбум, Олон улсын худалдаа логистикийн төв ХХК 0.9 тэрбум, "ХИХУГ" ОНӨААТҮГ 0.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан нь нийт алдагдлын 94.7 хувийг эзэлж байна.

2.3. Нийслэлийн ЗД-ын 2021 оны захирамжаар нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот 15 байгууллагын 2021 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг баталжээ. Уг захирамжаар 15 аж ахуйн нэгж нийт 279.7 тэрбум төгрөгийн орлоготой, 325.5 тэрбум төгрөгийн зардалтай, 45.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар НӨАУГ-тай контрактын гэрээг байгуулжээ. Дээрх гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүд 2021 онд нийт 267.0 тэрбум төгрөгийн орлого, 308.4 тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж, орлогын төлөвлөгөөг 10.7 тэрбум төгрөг буюу 3.8 хувиар дутуу бүрдүүлж, зардлын төлөвлөгөөг 17.0 тэрбум төгрөг буюу 5.2 хувиар илүү зарцуулжээ.

2.4. Борлуулалтын орлогын төлөвлөгөөг 5 аж ахуйн нэгж нийт 11.0 тэрбум төгрөг буюу 5.9 хувиар давуулж, 10 аж ахуйн нэгж нийт 17.7 тэрбум төгрөг буюу 19.4 хувиар дутуу бүрдүүлжээ. Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг 11 аж ахуйн нэгж нийт 22.9 тэрбум төгрөг буюу 7.6 хувиар дутуу, 4 аж ахуйн нэгж нийт 5.9 тэрбум төгрөг буюу 25.3 хувиар илүү зарцуулжээ.

Орлогын төлөвлөгөө тасарсан нь Ковид-19 цар тахлын улмаас үйлчилгээ авдаг аж ахуйн нэгжүүд ажиллаагүй, сургууль цэцэрлэгүүд цахимаар хичээллэсэн, гадаад валютын ханш өссөн зэрэг нөлөөлсөн байна.

<sup>12</sup> 33.2.6. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Нийслэлийн 2023 оны төсөвт орлогыг **36,214.6** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.
2. Орон нутгийн төсвийн байгууллага болон ОНӨААН-ийн тэвчиж болох урсгал зардлуудыг 5-50 хүртэл хувиар бууруулахад дунджаар **4,547.4** сая төгрөгөөр хэмнэх боломжтой.
3. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 2022 оноос 425.5 тэрбум төгрөг буюу 3.5 дахин нэмэгдсэн нь нийслэлийн төсөвт тодорхой хэмжээгээр ачаалал үүсгэхээр байна. Нийслэл, дүүргийн төсвийн төвлөрүүлэн захирагч нарын төсвийн сахилга, хариуцлагыг нэмэгдүүлж, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах.
4. Нийслэл, дүүргийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагуудтай байгуулж байгаа контрактын гэрээ, удирдах болон хяналтын зөвлөлийн эрх зүйн актаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлж алдагдлыг бууруулах.
